



# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ

Цуврал №9

2016 оны 1 дүгээр улирлын байдлаар

## Эдийн засгийн өсөлт

Эдийн засгийн бодит өсөлт 2016 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 3.1 хувьтай гарлаа.

Хүснэгт 1. 2016 оны I улирлын бодит ДНБ-ий өсөлт (салбаруудаар, 2010 оны үнээр)

	Бодит ДНБ	3.1%	100.0%
1 Хөдөө аж ахуй	0.2%	5.0%	
2 Уул уурхай, олборлолт	4.0%	130.5%	
3 Боловсруулах үйлдвэрлэл	-0.7%	-23.9%	
4 Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.1%	4.0%	
5 Барилга	0.3%	9.4%	
6 Бөөн/жиж. худалдаа	-0.6%	-19.6%	
7 Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-0.2%	-6.4%	
8 Мэдээлэл, холбоо	0.0%	0.5%	
9 Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.2%	5.4%	
10 Бүтээгдэхүүний цэвэр татвар	-0.1%	-4.9%	

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Дээрх өсөлтөд уул уурхайн салбар 16.2 хувь, барилга 27.5 хувь, хөдөө аж ахуй 3.7 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 0.6 хувиар өссөн нь голчлон нөлөөлжээ.


Харин боловсруулах үйлдвэрлэл 13.1 хувь, бөөний болон жижиглэн худалдаа 5.3 хувь, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 2.6 хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар 1.4 хувиар буурсан нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. ДНБ-ий өсөлт (салбаруудаар, 2010 оны үнээр)

	Салбарууд	2015Q1	2016Q1
	Бодит ДНБ	4.1%	3.1%
1 Хөдөө аж ахуй	10.5%	3.7%	
2 Уул уурхай, олборлолт	13.4%	16.2%	
3 Боловсруулах үйлдвэрлэл	10.9%	-13.1%	
4 Цахилгаан, хий, уур, агааржуулалт	5.1%	4.0%	
5 Барилга	28.1%	27.5%	
6 Бөөн/жиж. худалдаа	-7.6%	-5.3%	
7 Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1.0%	-2.6%	
8 Мэдээлэл, холбоо	2.0%	0.5%	
9 Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	8.9%	0.6%	
10 Бүтээгдэхүүний цэвэр татвар	-14.8%	-1.4%	

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Дүрслэл 1. Эдийн засгийн өсөлтийн задаргаа




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Тэмдэглэл: \* Урьдчилсан гүйцэтгэл

## Инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс 3 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 1.7 хувиар, Улаанбаатар хотын индекс 1.1 хувиар тус тус өсөв.

Дүрслэл 2. Инфляцийн задаргаа




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

Улаанбаатар хотын 3 дугаар сарын жилийн инфляцийг бүтцээр нь задлан авч үзвэл -113.9 хувийг (-1.3 нэгж хувь) мах, махан бүтээгдэхүүн, 34.4 хувийг (0.4 нэгж хувь) махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн, 12.8 хувийг (0.1 нэгж хувь) хувцас, -18.3 хувийг (0.2 нэгж хувь) орон сууц, ус, түлш, цахилгааны үнийн өсөлт бүрдүүлсэн бол үлдсэн 185.0 хувийг (2.0 нэгж хувь) бусад бараа, үйлчилгээний үнийн өсөлт бий болгосон байна.

Нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт үнэ тогтворжуулах хөтөлбөрийн нөлөөгөөр үргэлжлэн буурч байгаа бол импортын барааны инфляци алгуур саарч байна. Инфляци зорилтот түвшинтэйгээ нийцтэй болж буурч буй нь инфляцид нөлөөлөх ханшийн нөлөөлөл буурсаар байгаатай холбоотой юм.

Дүрслэл 3. Инфляцийн задаргаа




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

### Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл 2016 оны эхний 3 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 37.8 сая ам.долларын алдагдалтай гарсан байна. Урсгал данс 77.7 сая ам.долларын ашигтай, харин хөрөнгө санхүүгийн тэнцэл 31.4 сая ам.долларын алдагдалтай гарав.


Дүрслэл 4. Төлбөрийн тэнцэл



Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: \*Урьдчилсан гүйцэтгэл.

Урсгал дансны алдагдлын ДНБ-д эзлэх хувь 2016 оны эхний 3 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 3.3 хувь болоод байна.

Дүрслэл 5. Урсгал тэнцлийн бүтэц




Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: \*Урьдчилсан гүйцэтгэл.

Өмнөх оны мөн үед 28.3 сая ам.долларын алдагдалтай байсан төлбөрийн тэнцлийн урсгал данс 2016 оны эхний 3 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 77.7 сая ам.долларын ашигтай гарчээ.

Үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 8.5 хувиар буурч 229.4 сая ам.долларт, орлогын дансны алдагдал 25.3 хувиар буурч 166.5 сая ам.долларт, урсгал шилжүүлэг 3 дахин өсч 45.0 сая ам.долларт хүрсэн зэрэг нь урсгал тэнцэл ийнхүү сайжрах суурь нөхцөл болов.


Дүрслэл 6. Урсгал тэнцлийн санхүүжилт



Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: \*Урьдчилсан гүйцэтгэл.


Хөрөнгө, санхүүгийн дансны алдагдал тайлант хугацаанд 12.9 хувиар буурч 31.4 сая ам.долларт хүрчээ. Үүнд гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 141.7 сая ам.доллараар, гадаад зээл 288.2 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлжээ.

Дүрслэл 7. Хөрөнгө, санхүүгийн дансны бүтэц




Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: \*Урьдчилсан гүйцэтгэл.

Дүрслэл 8. Гадаадын шууд хөрөнгө оруулалт (сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: \*ДНБ-ий 2016 оны I дүгээр улирлын урьдчилсан гүйцэтгэл ашиглав.

**Дүрслэл 9. Гадаад худалдааны тэнцэл (с.и.ф нөхцөлөөр, сая ам.доллар)**



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар.

### Гадаад валютын улсын нөөц (ГВУН)

ГВУН 2016 оны 3 дугаар сарын байдлаар өмнөх оноос 4.4 хувиар буюу 58.6 сая ам.доллараар буурч **1265.3** сая ам.долларт хүрлээ.

Валютын төлбөртэй импортын дүн буурснаар импортын хэрэгцээг хангах ГВУН-ийн түвшин 7.0 сард хүрсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 1.0 нэгжээр илүү байна.

**Дүрслэл 10. Гадаад валютын улсын нөөц**



Эх сурвалж: Монголбанк.


Тэмдэглэл: Импортын хэрэгцээг хангах түвшинг ГВУН-ийг валютын төлбөртэй импортын сүүлийн 3 сарын дундаж үзүүлэлтэд харьцуулж тооцов.

### Гадаад худалдааны нөхцөл

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс (2012 оны суурьтай) 2016 оны 3 дугаар сард **1.263**-д хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **14.9** хувиар буурав.

Гадаад худалдааны нөхцөлийн индекс буурахад экспортын үнэ импортын үнийн индексээс илүү хурдацтай буурсан нь нөлөөлжээ.

**Дүрслэл 11. Гадаад худалдааны нөхцөлийн индекс**




Эх сурвалж: Монголбанк.

### Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш 2014, 2015 оны мөн үед харгалзан 26.2, 12.1 хувиар тус тус суларч байсан бол 2016 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс **3.0** хувиар суларч, **2046.4** төгрөгт хүрээд байна.

Харин гадаад худалдааны голлох түнш орнуудын валютын ханштай харьцуулсан нэрлэсэн үйлчилж буй ханш (NEER) **1.7** хувиар, инфляцийн зөрүүг оруулан тооцсон бодит үйлчилж буй ханш (REER) **1.2** хувиар тус тус чангарсан байна.

**Дүрслэл 12. Гадаад валютын ханш (жилийн өсөлтийн хувь)**



Эх сурвалж: Монголбанк.

## Улсын төсөв

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламжийн дүн 2016 оны эхний 3 сарын байдлаар **1095.2** тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн **1711.9** тэрбум төгрөгт хүрч, тэнцвэржүүлсэн төсвийн тэнцэл **615.7** тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

Нэгдсэн төсвийн орлогын тасралтад гадаад хандив, тусламж **106.0** тэрбум төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого **31.0** тэрбум төгрөг, импортын барааны НӨАТ **25.3** тэрбум төгрөгөөр тус тус тасарсан нь голлон нөлөөлжээ.

### Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө ба гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Нэгдсэн төсвийн орлого	Жилийн төлөвлөгөө	2016 оны I улирал			
		*	**	**/*	***
Нийт орлого ба тусламжийн дүн	7 072	1 242	1 095	88%	-11%
Тогтворжуулалтын сан	8	1	0	0%	-100%
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	7 063	1 241	1 095	88%	-11%
<i>I. Татварын орлого</i>	<i>5 588</i>	<i>968</i>	<i>972</i>	<i>100%</i>	<i>-11%</i>
1. Орлогын албан татвар	1 102	187	177	94%	-29%
1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	560	75	67	90%	-52%
1.2. Хувь хүний орлогын албан татвар	592	126	111	88%	-2%
2. Нийгмийн даатгалын орлого	1 173	250	267	107%	16%
3. Хөрөнгийн албан татвар	90	20	25	127%	49%
4. Дотоодын бараа, үйлчилгээний татвар	2 163	353	359	102%	3%
4.1. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1 442	215	228	106%	4%
4.2. Онцгой албан татвар	710	137	129	94%	2%
4.3. Тусгай зориулалтын орлого	11	1	2	161%	-25%
5. Гадаад үйл ажиллагааны орлого	404	63	55	87%	-3%
6. Бусад татвар, төлбөр, хураамж	656	95	90	94%	-53%
<i>II. Татварын бус орлого</i>	<i>1 475</i>	<i>273</i>	<i>123</i>	<i>45%</i>	<i>-10%</i>
1. Хөрөнгийн орлого	172	1	0	8%	-
2. Тусламжийн орлого	368	112	6	6%	-

Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: \*Төлөвлөгөө, \*\*Урьдчилсан гүйцэтгэл, \*\*\*Жилийн өсөлтийн хувь.

Төсвийн зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэл өмнөх оны мөн үеэс **24.6** хувиар буюу **337.9** тэрбум төгрөгөөр өсч **1711.9** тэрбум төгрөгт хүрч, **73.8** хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

### Хүснэгт 4. Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө ба гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Нэгдсэн төсвийн зарлага	Жилийн төлөвлөгөө	2015 оны I улирал			
		*	**	**/*	***
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	8 004	2 318	1 711	74%	25%
Урсгал зардал	6 272	1 737	1 430	82%	15%
1. Бараа, үйлчилгээний зардал	2 964	836	672	80%	12%
1.1. Далин хөлс	1 697	429	413	96%	3%
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	157	40	38	95%	3%
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	1 110	367	222	60%	34%
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	932	199	155	78%	141%
3. Татаас ба шилжүүлэг	2 376	702	603	86%	5%
Хөрөнгийн зардал	1 930	572	270	47%	99%
1. Дотоод эх үүсвэрээр:	1 517	467	143	31%	34%
2. Гадаад эх үүсвэрээр:	414	105	127	121%	339%
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-199	9	11	127%	-366%
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-941	-1 077	-616	57%	326%


Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: \*Төлөвлөгөө, \*\*Урьдчилсан гүйцэтгэл, \*\*\*Жилийн өсөлтийн хувь.

Төсвийн урсгал зардал өмнөх оны мөн үеэс 15.2 хувь буюу 188.1 тэрбум төгрөгөөр өсч **1429.6** тэрбум төгрөгт, хөрөнгийн зардал 99.0 хувиар буюу 134.3 тэрбум төгрөгөөр өсч **270.1** тэрбум төгрөгт, эргэж төлөгдөх цэвэр зээл 15.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж **11.2** тэрбум төгрөгт тус тус хүрчээ.

2016 оны эхний 3 сарын байдлаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл **-615.7** тэрбум төгрөг байгаа нь 2016 оны эхний улирлын ДНБ-ий **-13.1** хувьтай тэнцэж байна.

### Дүрслэл 13. Нэгдсэн төсвийн тэнцэл




Эх сурвалж: Сангийн яам.

## Мөнгө, санхүүгийн үзүүлэлтүүд

M2 мөнгийг актив талаас нь авч үзэхэд 2016 оны 3 дугаар сарын байдлаар дотоод цэвэр авлага өмнөх оны мөн үеэс **13.9** хувиар буюу **2** их наяд төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

### Дүрслэл 14. M2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа (актив тал)



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*ОСИСТБ хөтөлбөрийн зээлийн нөлөөллийг хасч тооцсон дүн болно.


Гадаад цэвэр актив 2016 оны 3 дугаар сарын байдлаар **-4.1** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.0 их наяд төгрөгөөр буурчээ. Харин сүүлийн 4 улирал дараалан сөрөг байсан M2 мөнгөний жилийн өсөлт **2.1** хувьтай гарчээ.

Пассив талаас нь авч үзвэл M2 мөнгөний өсөлтийн 2.8 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 1.4 нэгж хувийг M1 мөнгөний өсөлт, -0.8 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, -1.3 нэгж хувийг гадаад валютын харилцахын бууралт тус тус тайлбарлаж байна.

Өмнөх оны мөн үед мөнгөний нийлүүлэлтийн **-30.8** хувийг эзэлж байсан гадаад цэвэр актив 2016 оны 3 сарын байдлаар **-40.4** хувьд хүрч буурчээ. Ийнхүү M2 мөнгөний нийлүүлэлт дэх гадаад цэвэр активын огцом


бууралтыг бий болгосон гол хүчин зүйл нь 2012 оноос эхтэй төлбөрийн тэнцлийн хүндрэл юм.

Дүрслэл 15. M2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа (пассив тал)



Эх сурвалж: Монголбанк.

Дүрслэл 16. Мөнгөний үзүүлэлтүүдийн ерөнхий бүтэц ба хандлага




Эх сурвалж: Монголбанк.

### Банкны салбарын зарим үзүүлэлтүүд

2013 оны эхний хагас хүртэл тогтмол буурч байсан чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2016 оны 1 дүгээр улиралд 8.2 хувь болж өмнөх оны мөн үеэс 2.4 нэгж хувиар өсөв.

Дүрслэл 17. Чанаргүй зээлийн харьцаа (салбараар)




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*Татан буугдсан банкуудыг хасч тооцов.

Чанаргүй зээлийн харьцаа уул уурхайн салбарт 24.9 хувь, бөөний болон жигжлэн худалдааны салбарт 12.6 хувьтай байгаа нь дунджаас өндөр байгаа юм. Харин Анод, Зоос, Хадгаламж банкуудыг хасч тооцвол чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх харьцаа 6.3 хувьтай байв.

Дүрслэл 18. Зээлийн өсөлтийн задаргаа, чанаргүй зээлийн харьцаа




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*ОСИСТБ хөтөлбөрийн зээлийн нөлөөллийг хасч тооцсон дүн болно.

2016 оны 1 дүгээр улирлын байдлаар хадгаламжийн байгууллагуудын зээлийн өрийн үлдэгдэл 11.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар буурав. Энэ бууралтын -1.2 нэгж хувийг аж ахуйн нэгжид олгосон зээл, -3.5 нэгж хувийг иргэдийн зээл, үлдсэн 1.0 нэгж хувийг бусад салбар эзэлж байна.

Чанаргүй зээл ба нийт зээлийн харьцаа иргэдийн зээлийн хувьд 2010 оноос хойш тогтмол буурсаар 2014 оны 6 дугаар сард 0.9 хувьд хүрч байсан бол энэ оны эхний улиралд 3.0 хувьд хүрч өсөв.

Дүрслэл 19. Иргэдийн зээлийн жилийн өсөлт




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*Жижиг дунд үйлдвэрлэл.

Нийт зээлийн 43.2 хувийг эзэлж буй иргэдийн зээл 2016 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар буурчээ.

Дүрслэл 20. Иргэдийн зээлийн бүтэц (2016 оны 1 дүгээр улиралын байдлаар)




Эх сурвалж: Монголбанк

Тэмдэглэл: \*Жижиг дунд үйлдвэрлэл.

Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт системийн хэмжээгээр 2016 оны 3 дугаар сард 17.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар өсчээ. Энэ нь Монголбанкнаас тогтоосон шаардлагаас 5.4 нэгж хувиар өндөр үзүүлэлт юм.

Дүрслэл 21. Өөрийн хөрөнгө




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*Өөрийн хөрөнгө.

Харин төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт банкны системийн хэмжээгээр 2016 оны 3 дугаар сард 39.0 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.6 нэгж хувиар өсчээ. Энэ нь Монголбанкнаас тогтоосон шаардлагаас 14.0 нэгж хувиар өндөр байна.

Дүрслэл 22. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар.

Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү тайлант хугацааны эцэст өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар өсч, хадгаламжийн бодит хүү 11.6 хувьд хүрээд байна.


Дүрслэл 23. Банкны хадгаламж, зээлийн хүү



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*Хөтөлбөрийн зээлийг оруулсан болно.

Дүрслэл 24. Хүүний динамик



Эх сурвалж: Монголбанк.